



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/4021

Мөрөн


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5-ын "а", Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын 2.1.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2017 оны ээлжилт IV хуралдааны 01 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын олимпиадын гуравын даваанд амжилт гаргасан багш, сурагчдын урамшуулалд 2080.000 төгрөг, "Үл тасрах аялгуу" дууны улсын уралдаанд амжилттай оролцож түрүүлсэн ардын авъяастан Г.Батжаргалд 150.000 төгрөг, "Хоймор нутгийн түүхэн хөгжил" уран бүтээлийн бие даасан үзэсгэлэн гаргасан ахмад зураач Х.Баян-Очирт 200.000 төгрөг, "Дэгдээхэй нас" хүүхдийн бүжгийн улсын уралдаанд амжилт гаргаж хүрэл медаль хүртсэн "Өсөх нахиа" гуравдугаар цэцэрлэгийн бэлтгэл "а" бүлгийн бүжгийн хамтлагийн хүүхдүүдэд 200.000 төгрөг, "Уран эгшиг" улсын уралдаанд оролцож хүрэл медалиар шагнагдсан Г.Пүрэвнямд 120.000 төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлж, шагналтай холбогдон хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд гарах зардалд 979200 мянган төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 3729.2 мянган төгрөгийг Засаг дарга ерөнхий данснаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Л.ГАНБОЛД